



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН ЯАМ**

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 26-22-27, Факс: (976-11) 323589  
E-mail: info@mecss.gov.mn, http://www.mecss.gov.mn

2019. 08. 06 № 4/7013  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГА НАР ТАНАА

**Хамтран ажиллах тухай**

"Сурагчийн дүрэмт хувцасны тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/179 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг хүсье.

Батлагдсан загварын дүрэмт хувцсаар суралцагчийг хангах, худалдан борлуулах цэгийн талаар нэгдсэн мэдээллийг сургууль, эцэг эх, асран хамгаалагч нарт хүргэх арга хэмжээ авч, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ үү.

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН БОДЛОГЫН  
ГАЗРЫН ДАРГА Т.НЯМ-ОЧИР





МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2013 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/779

Улаанбаатар хот

Сурагчийн дүрэмт хувцасны тухай

"Бага, дунд боловсролын тухай" Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг, "Боловсролын тухай" Монгол Улсын хуулийн 28<sup>1</sup>.1.9 дүгээр заалт, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 186.5 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Хүүхдийн эрүүл ахуй, аюулгүй байдлын стандарт, шаардлагыг хангасан материалтай, нас, бие бялдрын онцлог, сонирхолд нийцсэн хийцтэй, монгол орны цаг агаар, уур амьсгалын онцлогт тохирсон, эдэлгээ, хэрэглээ даах чанартай, үнэ өндөр биш сурагчдын дүрэмт хувцасны загварыг 2013-2014 оны хичээлийн жилээс эхлэн мөрдүүлэхийг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт үүрэг болгосугай.

2. Батлагдсан загварын дүрэмт хувцсаар сурагчдыг нэгдсэн зохион байгуулалттайгаар хангах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Боловсролын газрын дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, арга зүйн дэмжлэг үзүүлэх, батлагдсан загварын мэдээллийг нэгтгэн танилцуулахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Эрдэнэчимэг/-т даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Суралцагчийн дүрэмт хувцасны тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 163 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.



Л.ГАНТӨМӨР

901606